



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/75

Булган сум

Таван аваргын нэрэмжит сар шинийн бөхийн барилдааныг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.7 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн харьяат Даншгийн их аварга Ш.Намхай, Даншгийн их аварга Ш.Лувсанжамбаа, Даян аварга С.Цэрэн, Даян аварга Х.Цэрэнпил, үндэсний бөхийн Далай даян, Дархан аварга Б.Түвдэндорж нарын алдарт таван аваргын нэрэмжит үндэсний бөхийн сар шинийн баярын барилдааныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Г.Алтанцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
Г.Алдармөнх (Соёл, урлагийн газрын дарга)
С.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын дарга)
Л.Ганбаатар (Цагдаагийн газрын дарга, хурандаа)
Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга,
хурандаа)

Нарийн бичгийн дарга: Б.Бат-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2. Бөхийн барилдааныг зохион байгуулахад шаардагдах 23,752,000 (хорин гурван сая долоон зуун тавин хоёр мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3.Бөхийн барилдааны арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 13-ний өдрийн А.Т.С дугаар
захирамжийн хавсралт

5 АВАРГЫН НЭРЭМЖИТ ҮНДЭСНИЙ БӨХИЙН САР ШИНИЙН БАЯРЫН
БАРИЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Бай шагнал	Тоо	Нэг бүрийн шагнал	Бүгд /мян.төг/	
1	2	3	4	5	
Томчууд					
1	7 давж түрүүлсэн	1	5 000 000	5,000,000	
2	6 давж түрүүлсэн	1	3 000 000	3,000,000	
3	5 давж шөвгийн 4-т үлдсэн	2	2 000 000	4,000,000	
4	4 давсан	4	800 000	3,200,000	
5	3 давсан	8	100 000	800,000	
6	2 давсан	16	60 000	960,000	
7	1 давсан	32	30 000	960,000	
Дүн		64		17,920,000	
Жаяг дэгийн баг					
1	Засуул	6	1	40 000	240,000
2	Цоллооч засуул	2	2	50 000	100,000
3	Хөлийн цэц	3	1	40 000	120,000
4	Гарын даа	2	1	40 000	80,000
5	Тайлбарлагч	1	1	50 000	50,000
6	Ерөнхий хөлийн цэц	1	1	50 000	50,000
Дүн		15			640,000
Бусад зардал					
1	Айраг	530л	7000		3,710,000
2	Хадаг	4ш	15 000		60,000
3	Ууц	1ш	500 000		500,000
4	Боорцог	20 кг	7000		140,000
5	Ус	100ш	2000		200,000
6	Медаль	4 ш	25 000		100,000
7	Өргөмжлөл	4 ш	33 000		132,000
8	Хулдаасан хэвлэл	20м ²	15 000		300,000
9	Эх бэлтгэл	1	50 000		50,000
Дүн					5,192,000
Нийт дүн					23,752,000